



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН М.БАДАМСҮРЭН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД**

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251
Утас: (976-51) 26 31 79, Факс: (976-11) 31 23 15,
Цахим шуудан: info@mrt.gov.mn,
Цахим хуудас: www.mrt.gov.mn

2025.11.13 № 01/5271

танай _____-ны № _____-т

Мэдээлэл хүргүүлэх тухай

Зүүн бүсэд хэрэгжиж буй Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 50 км хатуу хучилттай авто зам, Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 27 км хатуу хучилттай авто замуудтай холбоотой мэдээллийг хүргүүлж байна. Үүнд:

Нэг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2013 онд Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг гүйцэтгэхээр “Чайна гео инженеринг корпораци” ХХК, зөвлөхөөр “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ тус тус гэрээ байгуулан ажилласан. Тухайн авто замын барилгын ажлыг гүйцэтгэн 2015 онд улсын комисс ажиллуулсан боловч тухайн авто зам нь чанарын шаардлага хангаагүй гэж үзээд ашиглалтад хүлээн аваагүй байна.

Улмаар Зам, тээврийн хөгжлийн яам, “Чайна гео инженеринг корпораци” ХХК-ийн хоорондох “Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 50 км авто зам”-тай холбоотой шүүхийн маргаан 2016-2022 онд үргэлжилж, Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны 2017 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 101/ШШ2017/02239 дугаартай, мөн нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 210/МА2022/00930 дугаартай шүүхийн магадлалын дагуу Зам, тээврийн хөгжлийн яаманд “Чайна гео инженеринг корпораци” ХХК-аас 7.492.132.495,206 төгрөгийг гаргуулахаар Нийслэлийн Иргэний хэргийн Давж заалдах шатны шүүхээс хянан шийдвэрлэсэн. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас зохих суутгалыг уг төлбөрөөс суутгаж, “Чайна гео инженеринг корпораци” ХХК-иас 6.8 тэрбум төгрөгийг Зам, тээврийн хөгжлийн яамны дансанд 2023 оны 04 дүгээр сард шилжүүлсэн.

Монгол Улсын Засгийн газар Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын их засварын ажлыг “Монгол Улсын тээврийн холболт болон логиистикийн сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр Дэлхийн банктай харилцан тохиролцож, Зээлийн хэлэлцээрийг байгуулан 2024 онд Улсын их хурлаар соёрхон батлуулсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд А0502 дугаартай улсын чанартай Өндөрхаан–Чойбалсан чиглэлийн авто замын ПК50+000-ПК100+000 хоорондох 50 км хатуу хучилттай авто замын их засварын ажлын зураг төслийг “Ростов” ХХК боловсруулж, “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 463/2022 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан.

Дэлхийн банкны Худалдан авах ажиллагааны журмын дагуу тус авто замын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах олон улсын тендерийг 2024 оны 12 дугаар сард зарлаж, 2025 оны 07 дугаар сарын 29-ний өдөр гүйцэтгэгчээр БНХАУ-ын "Шандун Лүцяо Групп" компани шалгарч, 16,650,976.04 ам.долларын төсөвт өртөгтэй гэрээ байгуулсан ба талбайд авто замын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. Гэрээний хугацаа 2027 оны 07 дугаар сарын 27-нд дуусна.

Хоёр. Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар 2013 онд Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 27 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг гүйцэтгэхээр "Хансуун зам" ХХК, зөвлөхөөр "Ар Си Эс Си" ХХК гэрээ байгуулан ажилласан. Тухайн авто замын барилгын ажлыг гүйцэтгэн 2017 онд улсын комисс ажиллуулсан боловч тухайн авто зам нь чанарын шаардлага хангаагүй гэж үзээд ашиглалтад хүлээн аваагүй байна.

Гэвч тухайн авто замын гүйцэтгэгч "Хансуун зам" ХХК нь 2017 онд улсын комиссоос өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу дутуу ажлуудыг хийж гүйцэтгээгүй, гэрээний үүргээ удаа дараа зөрчсөн тул уг авто замын ажлын гэрээг Захиалагч 2020 онд 03/4127 тоотойр цуцалж, шүүхэд 4.6 тэрбум төгрөгийн нэхэмжлэл гаргасан ба шүүхийн маргаан эцэслэн шийдвэрлэгдээгүй үргэлжилж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар **2025 онд** А0502 дугаартай Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн авто замын 271-298 км хоорондох 27 км хатуу хучилттай авто замын их засвар, шинэчлэлтийн ажлыг хэрэгжүүлэхээр тусгагдсан ба Төрийн худалдан авах ажиллагааны газраас тендерийг зохион байгуулж, гүйцэтгэгчээр "Чандмань тал" ХХК шалгарч, 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр УТ2502808156/111 дугаартай гэрээ байгуулсан. Техник технологийн хяналтын зөвлөх "Гео урбан консалтинг" ХХК ажиллаж байна. Гэрээний хугацаа 2027 оны 10 дугаар сарын 30-ны өдөр дуусна.

Тус авто замын их засвар, шинэчлэлтийн ажлын инженерийн нарийвчилсан зураг төслийг 2023 онд "Ихэр мөнх" ХХК боловсруулж, "Зам тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын 2023 оны 310/2023 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан.

Тус авто замын барилгын ажлын талбайд даланг өргөсгөх, асфальтбетон хучилтыг хүйтнээр дахин боловсруулах, хиймэл байгууламжийн ажлууд хийгдэж байна. Нийт барилгын ажил 30 хувьтай хэрэгжиж байна.

Холбогдох материалуудыг хавсарган хүргүүлэв.

Нийт 700 хуудастай.